



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 69

Мандлагон

“Тогтвортой хөгжил-түншлэл” хамтын  
ажиллагааны зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.7, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.1, 15.1.4, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.2, 5.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг: “Тогтвортой хөгжил-түншлэл” төслийн хүрээнд орон нутгийн хөгжилд төр, иргэний нийгмийн байгууллага, уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн тэгш оролцоог хангасан, түншлэлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий аймгийн “Тогтвортой түншлэл-хөгжил” хамтын ажиллагааны зөвлөлийг 15 хүний бүрэлдхүүнтэйгээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулж ажилдуулсугай.

Хоёр: “Тогтвортой хөгжил-түншлэл”-д оролцогч талуудаас уг зөвлөлд төлөөлөн ажиллах гишүүдийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав: Зөвлөлийг ажиллах боломж нөхцлөөр ханган шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

Дөрөв: Сум орон нутгийнхаа хүрээнд салбар зөвлөл байгуулж ажиллахыг сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

ДАРГА С.Сүхбаатар



490219177

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын  
06 өдрийн 09 тогтоолын нэгдүгээр хавсралт

## “ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ-ГҮНШЛЭЛ” ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛД АЖИЛЛАХ ГИШҮҮД

Нэг. Аймгийн “Тогтвортой хөгжил-гүншлэл” хамтын ажиллагааны зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-д оролцох талуудыг төлөөлж доорх гишүүд ажиллана. Үүнд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлж:
  1. С.Сүхбаатар-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
  2. Ё.Дашням-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
  3. Б.Доржсүмбэр- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- Аймгийн Засаг даргын Тамгын газар, агентлагийг төлөөлж:
  1. Ц.Эрдэнэсүрэн-Аймгийн ЗДТГ-ын дарга
  2. Н.Эрдэнэ-Очир-Аймгийн Засаг даргын Тамгын газрын ХОХБТХ-ийн дарга
  3. Н.Гантулга-Аймгийн БОАЖГ-ын дарга
  4. Б.Мөнхжаргал-Аймгийн ХХААГ-ын дарга
  5. Г.Хишиглаваа- Аймгийн ХХҮГ-ын дарга
- Иргэний нийгмийн байгууллагыг төлөөлж:
  1. Б.Ням- Дундговь аймаг дах ХАҮТ-ын салбарын дарга
  2. Ж.Зоригтбаатар- АОЭХ-ны тэргүүн
  3. Н.Тогтох- Элгэмсэг дотно Дундговь холбоо ТББ-ын тэргүүн
- Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг төлөөлж:
  1. Н.Гамбаа- Сакура пропрети ХХК-ийн захирал
  2. О.Ганхуяг-Ган илч ХХК-ийн захирал
  3. Д.Баттөгс-Зуут констракшн ХХК-ийн захирал
  4. Н. Баярхүү- Хан дээж ХХК-ийн захирал
- Томоохон аж ахуйн нэгж /бизнес/-ийг төлөөлж:
  1. Б.Гантогтох-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, аймгийн Засаг даргын зөвлөх
  2. Д.Мягмар-Мандалговь хүнс ХХК-ийн захирал
- Орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагыг төлөөлж:
  1. Д.Баярмаа-Аймгийн ЗДТГ-ын ОНХМэдээллийн ажилтан
  2. Ө.Эрдэнэтунгалаг-Аймгийн ИТХ-ын мэргэжилтэн